

## **“ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ, ТҮҮНИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ” ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

### **“Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх” журмын төслийн тухай**

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ыг нийгмийн хамгааллын, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэж заасны дагуу ХНХС, ХЗДХС, ЭМСайдын 2017 оны А/173, А/281, А/380 дугаар хамтарсан тушаалаар батлагдан хэрэгжиж байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийг дагаж, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал, үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг баталж, гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд төрийн байгууллага хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Энэ хүрээнд “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам” (ХНХС-ын 2021 оны А/218 дугаар тушаал), “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ТББ-ыг магадлан итгэмжлэх журам” (ХНХС-ын 2021 оны А/210 дугаар тушаал, “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журам” ХНХС, ХЗДХСайдын 2021 оны А/190, А280 дугаар хамтарсан тушаал), “Хамгааллын үйлчилгээний норматив зардал, санхүүжүүлэх аргачлал” (ХНХС, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаал) зэрэг нийт 6 журам, 1 стандарт, 1 зардал тооцох аргачлалыг шинээр батлуулсан.

Түүнчлэн нийгмийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх тогтолцооны шинэчлэлийн хүрээнд Нийгмийн ажил, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулж, Нийгмийн ажил, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6949:2021 стандартыг батлуулж, Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан /НАМС/, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн сан /etuslamj.mn/ зэрэг мэдээллийн сангуудыг шинээр хөгжүүлээд байна.

Эдгээр хууль эрх зүйн болон цахим шинэчлэлийн хүрээнд зарим дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах ажлыг хэрэгжүүлж байна.

Сангийн яамнаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг хамтарсан багийн механизмаар дамжуулан хүргэх асуудлыг хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоотой хамтад нь авч үзэж, дээр дурдсан зарчмын хүрээнд цогцоор шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэний дагуу ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2022 оны А/23, А/27 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-тай уялдуулан “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулаад байна.

Журмын төслийг боловсруулахдаа улсын хэмжээнд санал авах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах, холбогдох байгууллагуудын санал, зөвлөмжийг судлан төсөлд тусгах ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн. Тухайлбал,

- 2021 онд Хүний эрхийн Үндэсний комисс болон Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар Хамтарсан багийн хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн зөвлөмж;
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчид, ТББ-ын төлөөллийн бүрэлдэхүүнийг оролцуулсан хэлэлцүүлэг;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудаас санал авах хэлэлцүүлэг;
- Нийслэлийн Хамтарсан багийн Нийгмийн ажилтнуудыг хамруулсан сургалт, хэлэлцүүлэг;
- Орон нутгийн Хамтарсан багийн гишүүдийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлгийг шат дараалан зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцсон төр, төрийн бус байгууллагын төлөөллөөс Хамтарсан багийн гишүүдийн чиг үүргийг тодорхой болгох, үйлчилгээний зардлыг тусгаж өгөх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах төсөвтэй болгох зэрэг асуудлыг журмын төсөлд тусгах тухай санал ирүүлсэн.

Энэхүү цогц үе шаттай хэлэлцүүлгийн үр дүнд шинэчлэн боловсруулсан журмын төсөлд дараах зохицуулалтыг шинээр тусгалаа. Үүнд:

- Хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг;
- Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүл, хүчирхийллийн хохирогч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хамгааллын болон урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэхэд зөвшөөрөгдөх зардлын төрөл, хэмжээг тооцох үйлчилгээний жишиг зардал;
- Хамтарсан багийн үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ;
- “Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний маягт” зэрэг болно.

Уг шинэчилсэн журмын төсөл батлагдсанаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, охид, эмэгтэйчүүдийг хамгаалах чиглэлээр анхан шатанд ажилладаг Хамтарсан багаас үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна гэж үзэж байна.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**